



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/752

Булган сум

Хяналт шалгалт хийх ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дах заалт, Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.11 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган сумын Ерөнхий боловсролын сургуулиудын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: М.Батчимэг (Аймгийн засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: Ж.Ганболд (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)
Ч.Баттуяа (Булган аймаг дахь Төрийн албаны
зөвлөлийн салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга)
Ж.Оюунгэрэл (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн Ахлах мэргэжилтэн)
Г.Нансалмаа (Боловсрол, шинжлэх ухааны газрын
Бодлого төлөвлөлт, захиргаа, аж ахуйн албаны дарга)
Б.Сэрчмаа (Боловсрол, шинжлэх ухааны газрын
хяналтын Улсын байцаагч)
М.Мөнхгэрэл (Хүнс, хөдөө аж ахуйн газрын хүнс, хоол,
үйлдвэрлэл үйлчилгээний хяналтын Улсын байцаагч)
П.Азхишиг(Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны
Санхүүгийн хяналт, шалгалтын Улсын байцаагч)
Н.Хүрэлсүх (Боловсрол, шинжлэх ухааны газрын
мэргэжилтэн)
Б.Энхтуяа (Боловсрол, шинжлэх ухааны газрын
мэргэжилтэн)
П.Шинэцэцэг (Цагдаагийн газрын Хүүхдийн гэмт хэргээс
урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Б.Бат-Эрдэнэ (Аймгийн засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсролын бодлого,
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн)

2.Булган сумын Ерөнхий боловсролын сургуулиудын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Булган сумын Ерөнхий боловсролын сургуулиудын үйл ажиллагаанд удирдамжийн дагуу хяналт, шалгалт хийх ажлыг чанартай, шуурхай зохион байгуулан, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин, дүнг аймгийн Засаг даргад тайлагнахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

11 дүгээр сарын 06-ны өдрийн А/752 дугаар захирамжийн хавсралт



БУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ УДИРДАМЖ

Үндэслэл: Багш, ажилчдаас ирсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, ерөнхий боловсролын сургуулиудын дотоод үйл ажиллагаа, сургалтын орчин нөхцөлтэй танилцах, зөвлөн туслах, хяналт шалгалт зохион байгуулах.

Зорилго: Ерөнхий боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгон сайжруулах, салбарын байгууллага, орон нутгийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх, багш ажилчдаас ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх.

Хяналт, шалгалтыг зохион байгуулах хугацаа: Тус хяналт, шалгалтыг аймгийн Засаг даргын Захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2023 оны 11 дүгээр сарын 06-наас 11 дүгээр сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- Сургуулийн санхүүгийн үйл ажиллагаа, төсөл хөтөлбөр болон шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хянаж, шалгах
- Газар, барилгын эзэмшилт, ашиглалт болон сургуулийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан, эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавих
- Багш, ажилчдын нийгмийн баталгааг хангах, хүний нөөцийн бодлого, чиглэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд хяналт, шалгалт хийх
- Сургуулийн хоол үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдлыг хангуулах, хяналт, шалгалт хийх
- Дотуур байрны үйл ажиллагаатай танилцах
- Өргөдөл, гомдолд нэр дурдагдсан багш, ажилчдаас тайлбар авах, асуудал тодорхойлох, шийдвэрлэх
- Багшийн ёс зүйн зөрчилтэй холбогдуулан багш, ажилчид, сурагчдаас судалгаа авах, уулзалт зохион байгуулах
- Байгууллагын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаатай танилцах, хяналт шалгалт хийх

Тайлагналт: Булган сумын Ерөнхий боловсролын сургуулиудын үйл ажиллагааны хяналт, шалгалтын дүн, тайлан мэдээг аймгийн Засаг даргад тайлагнаж, гарсан үр дүнгийн талаар холбогдох дээд байгууллагад санал, хүсэлт уламжлах, тайлан мэдээг хүргүүлэх